



ХӨСӨГ ТРЕЙД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сар 14 өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал тауэр, 902 тоот Хурлын танхимд болов.

Хуралд :

Ж.Энхтунгалаг 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Эй Ди Эм Эм Ди ХХК 96,357 ширхэг хувьцааны саналаар, Гүйцэтгэх захирал Ж.Гантогтох /өөрийн биеэр/
Д.Бадам 88,118 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
С.Жавзан-Орлом 54,311 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Г.Маргад 53,916 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
тус тус оролцож нийт 292,703 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 98.9% хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд болох Т.Өлзийбүрэн, Р.Гансүх, Ц.Дамжин нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Болор удирдав.

Хурлаар:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;

Хурлын дарга С.Болор: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулъя. Хурал хуульд заасан ирцийн шаардлага хангасан хүчин төгөлдөр бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 98.9% хувьтай байгаа тул Монголын Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрлийг Хурлын даргад өгөв.

Хурал 11 цаг 30 минутад эхлэв.

СОНССОН НЬ :

Хурлын дарга С.Болор: Энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нартаа энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд бүгдээрээ хувьцаа эзэмшигчдийн хурлаа эхэлье. Энэ удаагийн хурлаар дараах дэгийн дагуу асуудлыг хэлэлцэнэ. Хурлын дэг, хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулъя.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батална
3. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулна
4. Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариултыг явуулна
5. Тооллогын комисс саналын хуудас бөглөх заавар танилцуулж, саналын хуудсаар санал авна
6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна
7. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулна

Хэлэлцэх асуудлын дагуу Хурлын дарга С.Болор 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Хурлын дарга ТУЗ-н дүгнэлтийг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: Одоо ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулъя.

Хурлын дарга ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: Ийнхүү энэ хүрээд өнөөдрийн хурлаар танилцуулах зүйлс маань дуусаж байна. Одоо хурлын дэгийн дагуу танилцуулсан зүйлстэй холбогдуулан хувьцаа эзэмшигч нараас асуух асуулт байвал дарааллын дагуу асуугаад явъя. Өнөөдөр хуралд маань компанийн ТУЗ-н хараат бус гишүүн болон гүйцэтгэх захирал ирсэн байгаа тул хариулаад явна.

Хувьцаа эзэмшигч Ж.Гантогтох: Асуулт байхгүй ээ.

Хувьцаа эзэмшигч Д.Бадам: Нэмэлт тодруулга, санал байхгүй ээ.

Хурлын дарга С.Болор: Хувьцаа эзэмшигч нарт өөр санал байхгүй бол санал хураалтаа явуулъя. Саналаа саналын хуудсаар өгнө. Тооллогын комиссын дарга саналын хуудас хэрхэн бөглөх зааврыг хувьцаа эзэмшигч нарт танилцуулна уу.

Хурал 10 минут завсарлаад тооллогын комисс саналаа хурааж, дүнгээ гарган уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа: Хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын хуудасны дагуу дараах дүн гарч байна.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрсөн саналын тоо 292,703 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг хурлын дарга уншиж танилцуулан, хурлын материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэхийг дурдав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компани 2024 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулсныг дурдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 13 цаг 40 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :



С.БОЛОР

Б.АНХБАЯР